

# Социализмын болон түүний өмнөх, дараах үеийн Монголчууд: Тойм шинжилгээ ба бодлогын нөлөөлөл

Брюс М. Кнафт

**Редакторын тайлбар:** Энэхүү илтгэлд Монголын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын хөгжлийг хоёр ирт сэлэмтэй зүйрлэн үнэлсэн байна. Эдгээр нь нэг талаас байгалийн баялгаас олох ашиг, хүчтэй ардчилсан улс төр, нөгөө талаас баялгийн хуваарилалт, улс төржилт болон ирт хугацааны тогтворжилтын өртгөөр босох богино хугацааны нийгэм, улс төрийн тогтвортой байдал юм. Энэ номонд хувь нэмрээ оруулсан хүмүүсийн гаргаж тавьсан үзэл санал дээр тулгуурлан Монголын төрийн хөгжлийн талаар дүн шинжилгээ хийснээр бодлогын шинжтэй дараах санал дүгнэлтийг гаргасан байна. Үүнд: (а) илүү хүчтэй, тогтвортой, үндэсний хөгжлийн итгэлцлийн сан бий болгох; (б) сонгуулийн кампанит ажил, түүнийг санхүүжүүлэх арга замд шинэтгэл хийх; (в) хөдөө орон нутагт нийгмийн үйлчилгээ болон төрийн захиргааны тогтолцооны тодорхой хэсгүүдийг өөрчлөн зохион байгуулах; г) Монголчуудыг өөрсдийн өвөрмөц түүх, соёлын нөөц, эх сурвалжийг дахин үнэлэх чадвартай болгосноор тэд үндэснийхээ ирээдүйн зам болон ижилсэлиг тодорхойлоход итгэл дүүрэн болох юм.

Бүхэлд нь дүгнэхэд, энэ илтгэл хэдийгээр Монголд улсад сүүлийн жилүүдэд өрнөж буй өөрчлөлт, хөгжил нь тус улсад томоохон аюулыг учруулж болох ч Монгол улс “эрсдэлд үл өртөх” хэд хэдэн онцгой шинжийг гаргаж, үнэлэлт өгсөн байна.

---

Хятад, Оросын хооронд “хавчуулагдсан” далайд гарцгүй Монгол Улс нь Монголын эзэнт гүрэн задран унасан цагаас л эхлэн хэврэг төрийн тоонд багтаж ирсэн. Энэ байдал

нь XX зуунд Зөвлөлтийн ноёрхлын удаан үргэлжилсэн он жилүүдэд, мөн ардчилал, чөлөөт зах зээлийн харилцааг тогтоох Зөвлөлтийн дараах үеийн эхний жилүүдэд дахин мэдрэгдэв. Зөвлөлтийн нөлөөнд орохоос өмнө буюу 1691-1911 оны хооронд Монгол орон Манжийн Чин гүрний хяналт дор байжээ. Улмаар түүхэн талаас нь харах юм бол 1911-1920 оны хоорондох богинохон үеийг эс тооцвол 1990-ээд оны эхээр Монгол улс эрх чөлөөгөө дахин олж авсан нь гурван зууны харийн давамгайлал, хяналтаас ангижирч байгаа хэрэг болно.

Сүүлийн хорин жилийн хугацаанд Монголын үндэсний хөрөнгө баялгийн хэмжээ социализмын үеийнхээс хэд дахин нэмэгдсэн бөгөөд Монголын байгалийн баялгийг түшиглэсэн уул уурхайн салбар, ялангуяа нүүрс, зэс, флорит, алт, төмрийн хүдэр, молибден, газрын тос, фосфат, тугалга, уран, волфрамын олборлолтын нөлөөгөөр цаашид улам эрчимтэй нэмэгдэх төлөвтэй байна. Зарим нөлөө бүхий эх сурвалжийн тооцоолж байгаагаар 2013 он гэхэд Монголын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) жилийн өсөлт 23 хувьд хүрэх ажээ. Энэ өсөлт нь Монголын эдийн засаг, дэд бүтэц, барилгын салбарын эрчимтэй хөгжил, мөн сүүлийн арван жилд хүчээ авч буй хотжилтыг улам түргэтгэх юм.

Пост-социалист Монгол улс нь парламент, ерөнхийлөгчийн холимог засаглалтай, олон намын тогтолцоотой, идэвхтэй ардчилсан нийгэм болоод байна. Монголын ард түмний дунд төр засагтаа сэтгэл дундуур байх (улс төрийн намаас үл хамааран), төрийн өндөр түвшний албан тушаалтнуудын үйл ажиллагаанд үл итгэх явдал нэмэгдэж байгаа ч ардчиллын зарчмуудад итгэх итгэл хүчтэй хэвээр байна. Фрийдом Хаусын 2011 оны дэлхийн газрын зураг дээр Монгол улс Хималайн нуруунаас хойш байрлах эх газрын Азийн “эрх чөлөөгүй” улс орнууд, дэлхийн супер хүчнүүдээр хүрээлүүлсэн “эрх чөлөөний” томоохон арал болж тэмдэглэгджээ.

Чөлөөт зах зээлийн байр суурьнаас харах юм бол Зөвлөлтийн давамгайлал, улс төрийн хэлдэгдүүлэлтэд өртөж байсан түүхтэй, өндөр эрсдэлт улс орон хэрхэн бат бэх орчин үеийн ардчилсан засаг төр, эдийн засгийн хурдацтай өсөлт, орчин үеийн хэрэглээ, хэвшилтэй нийгэм болж хөгжсөнийг харуулах жишээ болж чадах улс бол Монгол юм.

Өөр өнцгөөс харах юм бол Монгол улс сүүлийн 20 гаруй жилийн ихэнхэд нь капиталист эдийн засагт огцом шилжсэнээс үүдэлтэй “цочирдлын” улмаас хүчтэй хямралыг мэдэрсээр ирсэн. Төвлөрсөн хяналт үгүй, капиталист харилцаанд шилжих явцад социалист нийгмийн үед хэвшээд байсан өргөн хүрээтэй нийгмийн дэмжлэгийн тогтолцоо задран унаж, хөдөө орон нутгийн зах зээлийн дэд бүтцийг сэргээх буюу шинээр бий болгож чадалгүй алдагдал амсахад хүргэж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох буудайг өөрсдөө тарьж, боловсруулах чадавхаа алдсан хэдий ч саяхнаас л сэргээж эхэлжээ. Эдгээр хүндрэл бэрхшээлийн зэрэгцээ хөрөнгө баялгийн ялгаа нэмэгдэн, Монголчуудын дунд ядуурал улам газар авсаар одоо өөрсдийнх нь тооцоогоор нийт хүн амын гуравны нэг нь ядуучууд болоод байна. Энэ утгаараа, Монгол улс өсөн нэмэгдэж буй ашигт малтмалын салбарынхаа хөгжлийг зөв залахын зэрэгцээ насаар залуу ардчиллаа бэхжүүлэхэд амжилт олж чадна гэсэн итгэл тун саяхнаас л бий болж эхэлж байгаа билээ.

Ашигт малтмалд тулгуурлан эдийн засгийн эрс өсөлтийг хангах Монгол улсын төрийн тооцоо, төлөвлөгөө нь олон ноцтой асуудлыг дагуулж мэдэх талаарх сэрэмжлүүлэг манай номын нэгэн чухал сэдэв болж олонтоо давтагдсан болно. Энэ сэрэмжлүүлгийн цаана орших хамгийн ноцтой асуудал бол Зөвлөлийн хяналт, дарангуйллын үед тогтсон “эрсдэлт төр” өнөөгийн байгалийн асар их баялгийн капиталист маягийн ашиглалтаас үүдэлтэй эрсдлүүдийг өөртөө агуулсан неолиберал “хэврэг төр”-өөр солигдох вий гэсэн болгоомжлол

юм. Энэхүү өргөн хүрээтэй олборлолт нь эцэстээ эдийн засгийн өсөлт болон ашиг орлогыг үндэсний эрх ашиг, нийтийн ашиг сонирхолд чиглүүлэн хянах, удирдан залах, зангидан чиглүүлэх үндэсний болон засаг төрийн чадавхийг сулруулан туйлдуулж мэдэх бөгөөд үүний зарим жишээ болгон зарим өгүүлэлд хөрөнгө баялгийн ялгарал эрчимжиж, үүнийг дагаад хөдөөгийн хүн амын амьжиргаа, хотжилт, ядууралтай холбоотой олон асуудал үүсэх болсныг дурьджээ.

Энэхүү сэтгэл эмзэглэм дүр зургийн зэрэгцээ Монголын ардчилал бэхжин хөгжих өөдрөг зураглал мөн харагдаж байна. Ардчилал нь тэнцвэртэй, урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжлийг Монголчуудад авчирна гэсэн итгэл найдвар үндэстний хэмжээнд бүрэлдэж байна. Үүнд харин ихэд газар аван дэлгэрсэн найз нөхөд, хамаатан садан, танил талдаа үйлчлэх байдал, улам бүр гүнзгийрсээр байгаа хөрөнгө баялгийн ялгаа, намын харъяаллаас үл хамааран төр засагт итгэх итгэл буурч буй явдал зэрэг нь бэрхшээл сорилт болж байна. Гэхдээ Төв Азийн бүс нутгийн ихэнх улс оронтой харьцуулахад эдгээр хандлага нь Монголд сул байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Харин уламжлалт малчин болон хот суурингийн хүн амын амьдралын хэвшил, амьжиргаанд гарцаагүй нөлөөлөх эдийн засгийн эрчимтэй өсөлт, гадаад ертөнцийн хүчтэй сонирхол, нөлөөнөөс үүдэлтэй ачаалал, дарамт нь Монголын хувьд хамгийн чухал асуудал болж ирэх магадлалтай.

Энэхүү өгүүллийг бичиж байх үед (2012 оны 5 дугаар сар) Монгол улсын Ерөнхийлөгч асан Намбарын Энхбаярыг тусгай албаныхны хүч оролцоотойгоор гэрээс нь баривчлан шоронд хорин, сар гаруй болсон үйл явдал тохиолдов. Барууны хэвлэлүүдэд түүний баривчилгаа, сэжиглэж буй гэмт хэрэг нь улс төрийн сэдэлтэй байж болох тухай бичиж байна. Өлсгөлөн зарлан, өмгөөлөгчтэйгөө байнга уулзаж чадахгүй байгаа түүнийг төрийн өндөр албан тушаал хашиж

байх хугацаандаа авилгын хэрэгт оролцсон гэсэн үндэслэлээр баривчилсан ч одоогоор албан ёсоор ял оноогоогүй байна. Түүний удирддаг улс төрийн нам энэ оны 6 дугаар сарын 28-нд болох Монголын парламентын сонгуульд амжилт олох, сонгуулийн дараа хүчтэй сөрөг хүчин болох магадлал бий гэж үзэж байгаа нөхцөлд барууны сонин хэвлэлүүд ийнхүү шүүмжлэлээ илэрхийлж байна.

Одоогийн болон хуучин ерөнхийлөгчдийг дэмжиж байгаа хүмүүс, тэдний хооронд үүсээд байгаа үзэл бодлын зөрүүтэй байдал нь одоогоор маш их туйлширч байх шиг харагдаж байна. Өнөөдөр Монголын нийгэмд өрнөж буй маргаан нь төр засгийн өндөр түвшинд авилга хэр газар аваад байгаа тухай, мөн одоо өрнөж буй эдгээр үйл явдал нь Зөвлөлтийн үеийн улс төр дахин сэргэж байгаагийн шинж тэмдэг үү, эсвэл хэтрүүлэн дөвийлгөсөн мэдэгдэл үү гэдэгт төвлөрч байна.

Монголын улс төр, эдийн засгийн хөгжлийн түүхэн болон соёлын орчин нөхцөл хамгийн чухал асуудал байсаар байгаа нь маргаангүй. Үүнийг онцлох үүднээс Монголд хэрэгжүүлсэн манай төсөл улс төрийн эдийн засаг болон түүх, соёлын холбоо хамаарал, энэхүү хамаарал хөгжлийг дэмжигч нөөц боломж болж болох тухай асуудлыг авч үзсэн юм. Тухайлбал, сөргөөр эргэж болох өнөөгийн зарим нөхцөл байдлыг сөргүүлэн хэлэхэд, түүхэн хөгжлийнхөө туршид бүр Монголын эзэнт гүрний ноёрхлын дийлэнх хугацаанд Монголчууд соёлын олон хэвшил, шашны баримтлалуудад хүлээцтэй хандаж, хамтран оршиж ирсэн юм. Социалист хувьсгалаас өмнө 400 гаруй жилийн туршид бурханы шашныг шүтэж ирсэн Монголчуудын ихэнх нь өнөөдөр ч бурханы шашны энэрэн нигүүлсэхүйн үзлийг ихэд дээдлэн, хүний ирээдүй нь түүний өнөөдрийн амьдралдаа ёс зүйг хэрхэн сахин баримтлахаас ихээхэн хамаарна гэсэн итгэл үнэмшилтэй амьдарч байна.

Хувь хүн өнөөдөр бурханы шашныг тухайлан шүтэж буй эсэхээс үл хамааран Монголын нийгэм нь бүхэлдээ маш хүчтэй ёс зүйн зарчмуудыг баримталсаар байгаа юм. Энэ нь өнөөдөр бурханы шашны зэрэгцээ, христийн шашин болон бөө мөргөлд хүлээцтэй хандаж, мөн шашин болон үндэсний ялгаварлын асуудлаар улстөржилт гаргахгүй байгаагаар илэрч байгаа юм. Монголчуудын энэхүү хүлээцтэй хандлага нь улс төрийн байгууллагуудын уян хатан байдал, шилжин суурьших эрх чөлөө болон байгаль орчноо шүтэх, машид хүндэтгэн хандах сэтгэлгээтэй хослон оршиж ирсэн түүхтэй.

Монголчууд өнөөгийн сорил бэрхшээлийг даван туулах, ирээдүйн боломжуудыг ашиглах бүтээлч арга замуудыг эрэлхийлж буй энэ үед Монголчуудын нүүдлийн мал аж ахуйгаас (мөн Монгол төрийн түүхэн уламжлалаас) улбаатай уян хатан бөгөөд дийлэнхдээ хүлээцтэй зохион байгуулалтын бүтцүүд нь судлан ашиглаж болох соёлын хийгээд түүхэн мэдлэг, туршлагын чухал эх сурвалж болох магадлалтай. Өнөөдөр түүхэн болон соёлын урьдач нөхцлүүд нь эдийн засгийн пост-социалист хөгжлийн замнал, барууны орнуудын бий болгосон орчин үеийн хэв маяг, гадаад улс оронд аялж, амьдарсан бодит туршлага, шашны бус харин Үндсэн Хуульт засаг төрийн тогтолцоо, өсөн нэмэгдэж буй Монголын үндэсний болон үндсэрхэг ижилсэл зэрэгтэй давхар давхар огтлолцож байгаа билээ.

Эдгээр хүчин зүйлийг XXI зууны Монгол Улс хэрхэн түшиглэн ашиглах, хэрхэн шинэ шинэ хослол, холбоо үүсгэх нь Монголын улс төр, эдийн засгийн хөгжлийг тодорхойлох суурь асуудал болоод байна. Монголд социализмын үеийн суртал ухуулгын хүчтэй нөлөө сарниж, архивын баримт материалууд бүх Монгол хүнд хүртээмжтэй болохын хэрээр Монголын түүх олон нийтэд илүү бүрэн дүүрэн нээгдэн, ойлгомжтой болохын хэрээр пост-социалист үеийн соёлыг шинээр ухамсарлан ойлгох үйл явц Монголд одоо л эхэлж

байна гэсэн нэгэн чухал дүгнэлт уг төслөөс гарч байгаа билээ. Улмаар Монголын үндэсний ухамсар, ижилслийн талаарх энгийн бөгөөд явцуу үндсэрхэг ойлголтыг шинэ судалгаагаар баяжуулан тэлэх, гүнзгийрүүлэх боломж байгаа нь тодорхой харагдаж байна.

## Өргөн хүрээтэй нөлөөлөл

Орчин үеийн Монгол улс нь эрсдэлд өртсөн улс орон буюу эмзэг төр хэмээх ойлголтын уламжлалт утга санааг илүү гүн гүнзгий ойлгоход тус нэмэр болж байна. Хөгжингүй төрийн зохист үйл ажиллагаанд боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ, дэд бүтцийн суурь үйлчилгээг үндэсний хэмжээнд хүртээмжтэй хангах, мөн хууль эрх зүйн тогтолцоогоороо дамжуулан хүний суурь эрхийг хангах, баталгаажуулах чиг үүргийг багтаан ойлгодог. Сонгодог “дампуурсан төр” (failed state)-ийн хувьд эдгээр чиг үүргийн хэрэгжилт сул юмуу огт байхгүй, эсвэл саад тотгор ихтэй байх, бүр хэрэгжүүлэхээс татгалзах нөхцөл байдал илэрдэг бол чөлөөт зах зээлийн орчинд нео-либерал үзэл хэт давамгайлаад ирвэл эдгээр чиг үүргийг хүртээмж багатай явцуу хүрээнд хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангахгүй байх, бусдад гэрээлэх, эсвэл явцуу ашиг сонирхлыг нийтийн эрх ашгаас дээгүүр тавьсан хувийн болон бизнесийн сонирхлын нөлөөнд автах зэрэг байдал бас илэрдэг байна.

Энэ эрсдэл нь цөөн хүн амынх нь нэлээд хэсгийг хөдөөний хүн ам эзэлдэг, өргөн уудам газар нутгийг хамрах төрийн бүтцүүдийн төлөвшил жигд бус, ашигт малтмалын олборлолт огцом нэмэгдэж байгаа Монгол Улсын хувьд бодит бэрхшээл болох магадлалтай. Өнөөдөр төрийн байгууллага, агентлагуудын үйлдлийг иргэдээ сайн сайхан амьдруулахад чиглэсэн бус харин төрийн эрх мэдлийг ашиглан ашиг хонжоо хайсан үйл ажиллагаа гэж харах хүн цөөнгүй байна.

Практик талаас нь харвал Монгол улсын ашигт

малтмалын үлэмж нөөц нь улс орноо хөгжүүлэн, төр засгаа бэхжүүлж чадсан Норвеги, Чили, Австралийн тавьсан замаар Монголыг замнуулах үү, эсвэл газрын хэвлий дэхь баялаг нь хараал болж хувирсан Нигери, Конго (Ардчилсан Бүгд Найрамдах Конго улс), Судан, мөн магадгүй Афганистан, Иракийн араас Монголыг хөтлөх нь уу гэсэн чухал асуулт өнөөдөр тавигдаж байна.

Нэг талаас тархуу суурьшсан нүүдэлчин хүн амын өвөрмөц нийгэм, соёлын түүхтэй Өвөр Азийн улс, үндэстэн болохын хувьд, нөгөө талаасаа бурханы шашинтай учраас Сахарын бүсэд байрлах Африкийн улс орнууд болон Европын улс орнуудын төрийн хөгжилд нөлөөлсөн хүчин зүйлсийн аль алинд нь хамаарахгүй байх магадлалтай.

Тухайлбал, Монгол улсын цөөн хүн ам, ардчилал, мөн төрийн хяналтаас харьцангуй ангид зах зээлийн харилцааг хөгжүүлэхийн төлөө тууштай бөгөөд стратегитай замнаж ирсэн нь энэ бүс нутагтаа онцгойрох шинж нь болохын зэрэгцээ Орос, Хятадын аль алиных нь нөлөөнд оролгүй тусгаар тогтносон улс болж чадсантай шууд холбоотой юм. Цаг хугацааны хувьд улиран холдсоор буй түүх эдүгээ үед дахин давтагдахгүй хэдий ч Ази тивээс Европын зах хязгаар, Номхон Далайн хэсгийг хамруулан Чингис хааны байгуулсан Монголын Эзэнт гүрний үлдээсэн өв, үр дагавар нь Монгол хүний хувьд ач холбогдлоо алдаагүй хэвээр байна. Харин Монгол улс үндэсний, бүс нутгийн болон даяарших хүчин зүйлсийн нөлөөгөөр хэрхэн цааш хөгжих нь XXI зуунд төрийн хөгжил, хүчтэй төр, эмзэг төрийн талаарх бидний ойлголт, төсөөллийг олон талаар өөрчлөх, тэлэх, гүнзгийрүүлэх жишээ болж ч мэднэ.

## **Тодорхой сэдвүүд**

Олон төрлийн мэргэжил боловсролтой, олон үндэстний төлөөлөгчид нэгнийхээ илтгэлийг хэлэлцэж, санал шүүмжээ



нэмэрлэх явцад цаг үеийн хэд хэдэн чухал, заримдаа урьдчилан таамаглаагүй сэдэв хөндөгдсөн юм.

- Эдийн засгийн хурдацтай өсөлт ба хөрөнгө чинээний ялгаа

Монголын эдийн засгийн хөгжлийн гайхалтай замнал болон хэтийн хурдацтай өсөлтийг хөрөнгө чинээний ялгаа нэмэгдэх үзэгдэл дагалдаж байгаа тухай асуудал хөндөгдлөө. Үүнд хот, хөдөөгийн хоорондын ялгаанаас гадна хөдөөний малчин өрхүүд Улаанбаатар хот руу олноороо шилжин суурьших болсны үр дүнд өнөөдөр улсын нийт хүн амын гуравны нэгээс илүү хувийн оршин суух газар болоод байгаа Улаанбаатар хотын хэмжээнд илэрч буй баян, ядуугийн ялгааны асуудал багтаж байлаа. Хөдөө орон нутагт ч малын тоо толгой, улмаар хөрөнгө чинээний ялгаа өсөн, улс төрийн непотизм болон төрийн дэмжлэг, үйлчилгээний хүртээмж улам тэгш бус болсоор байгааг системтэй судалгаа болон аман мэдээлэл харуулж байна.

Уул уурхайгаас олох орлого, мөн голдуу гадны компаниудын оролцоо нь төрийн үйлчилгээний хуваарилалтад хэрхэн, хэдий хэмжээнд нөлөөлж болох, нөлөөлж чадах нь хамгийн чухал асуудал болоод байна. Эдгээрийн нөлөөгөөр төрийн үйлчилгээ хот, хөдөөгийн хүн амд тэгш хүртээмжтэй болон тэлж өргөжих үү, эсвэл эсрэгээрээ хумигдан хязгаарлагдаж, цөөн хэдэн хүний хүртээл болох уу?

- Эдийн засгийн капитал, хүний капитал ба засаг төр  
Өнөөгийн байдлаар Монголын эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсэг нь гадаадын хөрөнгө оруулалт болон үүнээс үүдэлтэй дотоодын хувийн ашиг, төсвийн орлого хэлбэртэй байна. Монголын эдийн засаг, нийгмийн

хөгжлийг ашигт малтмалын олборлолт, үүний дотор гадны олборлох компаниудын үйл ажиллагаанаас хараат болгохоос сэргийлэхийн тулд Монголчуудын чадавхи, хүний капиталыг хэрхэн зохистой дэмжих, нэмэгдүүлэх асуудал маш чухал болж ирж байна.

Өнөөдөр уул уурхай, түүнтэй холбоотой салбаруудад шинээр бий болохоор төсөөлөгдөж буй ажлын байрны тоо нь мэргэжилтэй Монгол боловсон хүчний нөөцөөс даваад байна. Энэ байдал ялангуяа технологи, инженерийн салбарт хүчтэй мэдрэгдэх ажээ. Монголын эдийн засгийн хөгжилд, ялангуяа өндөр зэрэглэлийн мэргэжлийн болон бизнесийн удирдлагын албан тушаалд гадаадын ажилчид давамгайлах магадлал тун бодитой болоод байна.

Гэтэл нөлөө талаас, өмнөх нийгмийн зөвлөлт маягийн боловсролын тогтолцооны үлдээсэн өв гэж тодорхой хэмжээнд үзэж болох бичиг үсгийн маш өндөр түвшин (нийт хүн амын 98 хувь нь бичиг үсэг тайлагдсан), мөн боловсрол олох, сурлагын амжилт гаргах хүчтэй хүсэл эрмэлзэл нь Монголчуудын давуу тал болдог. Тэд ерөнхийдөө гадаад хэлний мэдлэг сайтай бөгөөд Англи хэлээр ярих хүний тоо нэмэгдэж байгаагийн дээр зөвлөлт засгийн үед Монгол оюутнууд математик, байгаль шинжлэлийн чиглэлээр амжилттай суралцаж байснаас харвал тоо, тооцоолохуйд авьяастай хүмүүс юм.

Ашиглаж болох боломжууд нь эрсдэл, сорилтой ээлжлэн байгаа энэ үед эдийн засгийн хурдацтай өсөлт Монголчууд, Монголын нийгмийн чадавхийг сорихын зэрэгцээ боловсролын салбарт төр засгийн үүрэх ачааллыг нэмэгдүүлэн, мөн шинэ боломжуудыг нээж өгчээ. Эдгээрийн дотор судалгаанд чиглэсэн эрдэм

шинжилгээний салбаруудыг хөгжүүлэх, мөн мэргэжлийн хувьд чадварлаг боловч уян хатан бус, нийгмийн хөгжлөөс хоцорч байгаа зөвлөлтийн үеийн эрдэмтэн олонтой үндэсний гол хоёр их сургуульд дэмжлэг үзүүлэх асуудал багтаж байна. Олон салбарт, ялангуяа техник, технологийн салбарт өндөр боловсрол эзэмшсэн, мөн эзэмших чадахитай монголчуудын тоо нэмэгдэж байгаа нь шинэ боломж болж байгаа бол гадны нөлөө нэмэгдэн, чадварлаг Монголчууд өөр улс орон, өөр салбарт татагдах эрсдэл бас байгаа ажээ.

Сонгууль, ардчиллын бусад өрсөлдөөнт үйл явцуудад улс төрийн нам, улс төрчдийн хувийн сонирхол хүчтэй нөлөөлж буй энэ цаг үед улсын төсвийг үр өгөөжтэй хуваарьлах, мэргэжлийн сургалт, судалгааны байгууллагуудыг удирдах хариуцлагатай менежментийн тогтолцоог бүрдүүлэх нь нэмэгдэж буй хотын ядуу бүлгүүдэд хүрч буй боловсролын чанарыг доройтуулахгүй байхтай адил тун амаргүй ажил юм. Хот, хөдөөгийн алинд нь ч ялангуяа эрэгтэйчүүдийн ажилгүйдэл, архидалт зэрэг нийгмийн хүндрэлтэй асуудлууд нь боловсролын чанартай үйлчилгээг хүргэх, мэргэжлийн ур чадварт сургах төрийн чиг үүргийн хэрэгжилтийг улам хүндрүүлж байна. Эдгээр сорилт бэрхшээл нь эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэх ойрын жилүүдэд улам гүнзгийрэх магадлалтай.

- Эдийн засгийн өсөлт ба байгаль экологийн асуудлууд Монголын асар уудам тал хээр нутгийн ихэнх хэсэг нь дэлхийн дулаарал, хур тунадасны хомсдлоос үүдэлтэй ачаалал, дарамтад өртөөд байгаа экологийн эмзэг бүсүүд юм. Ус бол амин чухал ховор нөөц бөгөөд усны хэрэгцээ ихтэй уул уурхайн олборлолт, үйлвэрлэлийн салбарын

компаниуд газар нутгийн гол гол бүсүүдэд усны нөөцийг өөрийн дур мэдлээр ашиглаж байгаа, эсвэл ашиглахаар тэмцэлдэж байгаа дүр зураг харагдаж байна. Гүний худаг гарган усны хангамжийг нэмэгдүүлж болох ч энэ нь уст давхаргыг шавхан, хөрсний усны түвшинг бууруулж, ирээдүйд усны хямрал үүсэх шалтгаан болох юм. Том хэмжээний ил уурхай ажиллуулсны үр дагавар болох газар ашиглалт, экологийн доройтлын асуудлууд нь Монголын хөдөө нутгийн эдийн засгийн гол түшиц, мөн соёлын үнэт зүйл, нийгмийн зохион байгуулалт үндэс болсоор буй нүүдлийн мал аж ахуй, тэр дундаа малчин өрхийн амьдралд нөлөөлж байгаад ч мөн анхаарах ёстой юм.

Монголын хахир өвлийн хүйтнийг давж гарахын тулд нийслэл Улаанбаатар хотод ашиглаж буй зөвлөлтийн үеийн нүүрс түлдэг төвлөрсөн дулааны цахилгаан станцууд, орооцолдсон замын түгжрэл, мөн мод, нүүрс, хог хаягдал, бүр машины дугуй гээд шатаж болох бараг бүх л материал ашигладаг гэр хорооллынхны гаргаж буй утаа нь нийлээд хотын агаарыг бохирдуулна. Жилийн дийлэнх саруудад хотын агаараар амьсгалах нь хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй болоод байгаа бөгөөд өвлийн цэлмэг өдөр ч хэдхэн метрээс цааш юм харагдахгүй болж буй.

Байгаль орчны эдгээр асуудал нь Монголын засгийн газар болон нийгмийн төлөвлөлт, менежмент хариуцсан байгууллагуудын хувьд томоохон сорилт болоод байгаа юм. Усны хомсдол, газрын эвдрэл доройтол, агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлтийг нөлөөг багасган, байгаль орчны урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулан, тууштай хэрэгжүүлэхэд гадаадын уул

уурхайн компаниудын сонирхол, хөрөнгө оруулалтыг хэрхэн ашиглаж, чиглүүлж чадах нь Монголын XXI зууны тогтвортой хөгжлийн гол асуудал болоод байна.

- Үндэсний ухамсар буюу ижилсэл, шашин, Монголын түүхэн соёлын өв

Монгол дэлхий дахинд нөлөөгөө үзүүлсэн улс төр, соёлын баялаг түүхтэй улс. Үүнд өргөн уудам нутгийг хамарсан Монголын Эзэнт гүрний түүх багтаад зогсохгүй бие биенийхээ хөгжилд нөлөөлөхийн зэрэгцээ нийгэм - улс төрийн харилцан дэмжлэг болж өгсөн нэг талаас Төвдтэй тогтоосон холбоо, нөгөө талаас Манжийн үеийн Хятад улстай тогтоосон холбоо багтаж байгаа юм. Монголын бурханы шашин нь соёлын болон үнэт зүйлсийн баримжаа болох утгаараа эдгээр харилцааны хүрээнд болон бүр түүнээс ч давсан хүчирхэг нөлөөтэй байж ирсэн. Гэтэл бурханы шашин Монголд дотоодын эсэргүүцэл тэмцэл, мөн зөвлөлт засгийн хяналт дахь далан жилийн туршид элдэв хавчилга, устгал сүйтгэл зэргийг туулж иржээ. Үүнээс ч аймшигтай нь хэдэн арван мянган лам хувраг, тэдгээрийн дотор эрдэмтэй томоохон лам нар хэлмэгдүүлэлтэд өртөн амь насаа алджээ. Өнөөдөр Пүрэвбат лам зэрэг хүмүүсийн хичээл зүтгэлээр Монголын шашин, урлагийн уламжлал сэргэн, улам баяжихын хэрээр энэхүү урлагийн соёл, үндэсний болон шашны ач холбогдол хүчтэй болж байна.

Монголын материаллаг болон соёлын түүхийн олон өв устгагдаж, олон нийтийн хүртээл болоогүй бөгөөд зөвлөлтийн хяналт тогтоод байсан үед Монголын түүхийг үзэл суртлын үүднээс тайлбарлан бичдэг байсан учраас олон Монгол хүн саяхнаас л өнгөрсөн үеийнхээ үнэн түүхийг илүү сайн мэдэх болсон байна. Өнгөрсөн

үеийн түүх бол XXI зууны пост-социалист Монгол улс, Монгол хүнд өөрийн болон үндэсний дүр төрх, ухамсараа төлөвшүүлэхэд нэн хэрэгтэй соёлын өвийн нөөц, чухал эх сурвалж юм.

Гэхдээ улс төрийн утга агуулгатай чухал баримтын зэрэгцээ Зөвлөлтийн үеийн өдөр тутмын энгийн материал, түүнээс өмнөх Монголын түүхийн сурвалж материалыг олон мянгаар нь хадгалж байдаг Монголын түүхийн архивыг олон нийтэд бүрэн нээх асуудал саяхнаас л улс төр, нийгмийн санаачилга болж гарч ирж байна. Архивыг хаалттай байлгах гэсэн цөөн хэдэн хүний сонирхол, тэдний дэмжиж буй архивт нэвтрэх эрхийг хязгаарласан журам нь Зөвлөлтийн үед болж өнгөрсөн өргөн хүрээтэй олон үйл явдлын тухай баримт сэлтээс өнөөдөр ч чухал албан тушаал хашсаар байгаа юмуу нийтийн танил бусад хүмүүстэй холбоотой улс төрийн болон хувийн чанартай эмзэг мэдээлэл нийтэд дэлгэгдэхээс болгоомжилж буйтай нь холбоотой бололтой. Түүхийн бүхэл бүтэн үед хамааралтай баримт материалуудыг “төрийн нууц” биш юмаа гэхэд “нууц” гэсэн хэт ерөнхий ангилалд багтааж үзэх нь олон нийтийн мэдэх эрхийг хязгаарлаж байгаа юм.

Улмаар, Монголын засаг төр, зах зээлийг “нээлттэй” болгоод байгаа ардчилсан болон нео-либерал үзэл баримтлалын ачаар Монголын түүх, соёл, урлаг болон үндэсний ухамсар/ ижилсэлд тэдгээрийн үзүүлэх нөлөөллийн тухай асуудал саяхнаас л нийгмийн анхаарлыг татах болжээ. Архивыг улам нээлттэй болгох, мөн нийгэм-улс төрийн болон эрдмийн судалгаа, шинжилгээний салбаруудыг дэмжих хөгжүүлэх нь Монголын түүхийн шинэ аспектиудыг нээх, улмаар

Монголын үндэсний ухамсар/ ижилсэлийг ойлгох, шинээр тодорхойлох, төлөвлшүүлэх үйл явцыг өнгөрсөн үеийн хүчтэй үзэл суртлаас, нөгөө талаас эдийн засгийн хөгжлөөр бүх асуудлыг шийднэ гэсэн сайхан ч гэлээ зарим тохиолдолд биелэшгүй нео-либерал амлалтаас салган холдуулахад тустай юм.

- **Монголын соёл, улс төр, эдийн засгийн өсөлт**

Дээр дурьдсанчлан, орчин үеийн Монголын нийгэмд хурдацтай өрнөж буй нийгэм-эдийн засаг, улс төрийн өөрчлөлтүүдээс үүдэлтэй сорил бэрхшээл, мөн шинэ боломжууд нь сайн төр гэж юуг хэлэх, түүнийг хэрхэн хөгжүүлэн дэмжихтэй холбоотой шинэ шинэ асуултыг үүсгэх боллоо. Монголын төр капиталист хөгжил (үүний дотор Монголын байгалийн баялгийн ашиглалт, үүнд чиглэсэн хөрөнгө оруулалт)-ийг удирдан бий болгож байна уу, эсвэл энэ хөгжлийн нөлөөгөөр өөрөө өөрчлөгдөн төлөвшиж байна уу гэсэн асуулт өөрөө чухал болж ирэхийн зэрэгцээ хариу нь хараахан тодорхой болоогүй байгаа явдал нь нэн чухал болоод байна.

Энд бидний анхаарах ёстой суурь асуудал бол Монголын эдийн засаг, улс төр, соёлын харилцан уялдаатай хөгжлийн замнал юм. Сүүлийн үед Монголын эдийн засгийн хөгжил, улс төрийн харилцааны асуудлууд их анхаарал татах болсон ч эдгээрийн хоорондын харилцан хамаарал, ялангуяа эдгээр нь үндэстний хандлага, ойлголтыг тодорхойлдог үндэсний соёлын чиг баримжаатай хэрхэн уялдаж байгааг авч үзсэн нь нэн ховор. Энэ нөхцөлд бидний энэхүү төсөл Монголын эдийн засаг, улс төрийн хөгжилд үндэсний соёлын үзүүлэх хам нөлөө, харилцан нөлөөлөл, мөн тэлэх болон хязгаарлах нөлөөтэй соёлын хүчин зүйлсийн асуудлуудад

төвлөрсөн юм. Төслийн туршид өрнөсөн хэлэлцүүлэг, мэтгэлцээн, харилцан ярианы үр дүнд ялгаатай байр суурь, үзэл бодлуудын дундаас шинэ ойлголт, шинэ мэдлэг, идэвхтэй харилцаа үүссэн нь оролцогч бүх талд өгөөжтэй зүйл боллоо.

### **Эерэг өөрчлөлт, тэдгээрийн хэрэглээ**

Дээр дурьдсан орчин үеийн Монголын нийгэмд тулгарч буй сорил, бэрхшээлүүд нь Монгол улсын сүүлийн хорин жилд олсон чухал амжилт, дэвшлийг үгүйсгэх үндэслэл болж чадахгүйн нэгэн адилаар эдгээр амжилтаар бахархах бидний бахарлыг ч мөн дарж чадахгүй билээ.

Энэ хугацаанд Монгол улс зөвлөлтийн хяналтаас ихээхэн хамааралтай, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн багатай улс орноос бүрэн эрх чөлөөт, олон намын тогтолцоотой идэвхтэй ардчилсан улс болж, эрчимтэй эдийн засгийн өсөлт, дэд бүтцийн хөгжлийг бүтээж буй, өндөр боловсролтой, зарим хүний хувьд бүр Чингис хааны Монголын Эзэнт гүрэн, түүнээс ч өмнөх үеэс улбаатай үндэсний бахархал, ижилсэл бүхий нийгэм болжээ. Энэ бол аль эртнээс л бий болсон дэлхийн хэмжээний нөлөөгөө XXI зуунд ч хадгалсаар буй Орос, Хятад хоёрын хооронд “хавчуулагдан” Төв Азийн цээжинд орших 3 сая хүрэхтэй үгүйтэй хүн амтай улсын хувьд нэн бахархууштай дэвшил мөн. Харин Монгол улс неолиберал зах зээлийг баримжаалан хөгжих явцдаа нийгмийн хөгжилд хөрөнгө оруулах зорилтыг бага анхаарсан буюу огоорсны улмаас нийгмийн ихэнх ахиц дэвшил нь өнөөдөр амжилт олсон хөрөнгөтөн, улс төрч болоод буй хэдхэн хүний хүртээл болжээ гэж хэлэх үндэслэл бас байна.

Эерэг бөгөөд конструктив талаас нь харвал уг “Социализмын дараах Монголчууд” төслөөс дараах тодорхой, практик дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

- Хүчтэй, өргөн хүрээг хамарсан үндэсний тогтвортой хөгжлийн итгэлцлийн сан (trust fund) байгуулах



Норвегиас авахуулаад Папуа Шинэ Гвиней зэрэг олон улс байгалийн баялгаас олсон гэнэтийн ашиг орлогоо улс орныхоо өнөөдрийн хэрэглээ болон улс төрийн хуваарилалтаас чанагш урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахуйц байдлаар ашиглаж чадсан. Харин Монголын төр засаг үүний эсрэг чигт явах эрсдэл харагдаж байна. Улс төрчид сонгогчиддоо бэлэн мөнгө амлана. Монгол улсын иргэн бүрт уул уурхайн аварга том төсөл болох Таван Толгойн уурхайн 538 хувьцаа (Эрдэнэс Таван Толгой компани) тараах тухай шийдвэр гараад байна. Нэгэнт хэрэгжээд эхэлсэн бол иймэрхүү арга хэмжээ нь багасгах, хумих, зогсооход улс төрийн хувьд нэн төвөгтэй “авах эрх” болж хувирдаг бөгөөд энэ нь олон улсын уул уурхайн корпорациудын явцуу сонирхлоо лавшруулах, тулгах суваг болоход хялбар байдаг.

Хэдийгээр уул уурхайн орлогод түшиглэсэн итгэлцлийн сан байгуулах зарим оролдлого Монголд хийгдэж байгаа ч олборлолт нэмэгдсээр байгааг харгалзан энэ чиглэлийн хүчин чармайлтыг улам өргөжүүлэн, хөрөнгийн менежментийг олон нийтэд илүү ил тод, оролцоотой болгох шаардлагатай байна. Өнөөдрийн дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхийн зэрэгцээ баялгийн илүү тэгш хуваарьлалтыг хангах үүднээс хүний нөөцийн хөгжилд хөрөнгө оруулах, үүний дотор боловсрол болон хөдөлмөр эрхлэлтийн дунд болон доод сегментүүдэд анхаарах нь Монголын ирээдүйд нөлөөлөх чухал асуудлууд болж байна.

Сонгогчдын таашаалд нийцүүлэн хөрөнгө мөнгөө өнөөгийн хэрэглээнд зарцуулах сонирхол өндөр байгаа энэ үед үлэмж хэмжээний орлогыг удаан хугацааны тогтвортой хөгжилд зориулахаар нөөцлөх нь улс төрийн хувьд хүндрэлтэй байж мэднэ. Гэхдээ улс орны урт

хугацааны тогтвортой хөгжил, илүү шударга ирээдүйг хангах арга зам болох утгаар нь тогтвортой хөгжлийн ул суурьтай эрх зүйн орчинг тууштай сурталчлах үйл ажиллагаа нь өөрөөр улс төрийн дэмжлэгийг авчрах юм.

- Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн шинэчлэл / хууль эрх зүй

Хэдийгээр Монголын сонгуулийн үйл явцын шинэчлэл, төгөлдөршилтийн асуудал нь бидний энэхүү төслийн голлох сэдэв анхнаасаа байгаагүй ч бэл бэнчин, нөлөө ихтэй зарим хувь хүмүүсийн танил тохой татах, ивээн тэтгэх зан үйл сонгуулийн дүнд хэрхэн хүчтэй нөлөөлж байгаа асуудал манай төслийн явцад хөндөгдсөн юм.

Монголд гадаадаас орж ирэх хөрөнгийн хэмжээ их, мөн өсөн нэмэгдэж буй хөрөнгө чинээний ялгаанаас үүдэлтэй хүндрэл бэрхшээл багагүй байгааг харгалзан үзвэл сонгуулийн кампанит ажил, сонгуулийн санхүүжилт болон үүнд зориулсан хандивын хэмжээнд маш тодорхой хязгаар тогтоон, тодорхой хязгаарлалтуудыг тавих нь Монголын урт хугацааны өсөлт, тогтвортой байдалд нөлөөлөх чухал асуудал гарцаагүй мөн. Дээрхийн нэгэн адил, ийм санал санаачилга нь богино хугацаандаа улс төрийн хувьд боломжгүй зүйл мэт харагдаж болох ч энэ асуудлыг сонгогчдод ил тод, үндэслэл сайтайгаар хүргэх юм бол харин ч тэдний дэмжлэгийг авах болно.

- Орон нутгийн засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт

Өнөөдрийг хүртэл хийгдсэн судалгаануудаас харахад бэлчээрийн мал аж ахуйн салбар дахь дарамт ачаалал, бэрхшээлүүд нь хөдөө орон нутагт баялгийн тэгш буй байдлыг улам гүнзгийрүүлж байна гэж дүгнэж болохоор байна. Цөөн малтай малчид мал аж ахуйгаа орхин нэг бол

олон малтай өрхийн цалинтай малчин болох, эсвэл малаа зараад малчин ахуйгаасаа бүрмөсөн холдож Улаанбаатар, бусад жижиг хотын ядуу хороололд суурьших эрсдэлтэй тулгарах нь нэмэгдэж байгаа ажээ.

Өнөөгийн улс төрийн зохион байгуулалтаар бол орон нутгийн түвшний маргаан, хүсэлт (жишээлбэл, отрын нутагт орж өвөлжих эрх хүсэх)-ийг зохицуулахад орон нутгийн засаг захиргаа оролцох эрхтэй ч ийм үүрэггүй болно. Энэ нь эрсдэлд ороод байгаа өрхүүдийн асуудалд ч мөн хамааралтай зохицуулалт юм. Тиймээс эрсдэлд өртөх магадлалтай ч тодорхой хүндрэл бэрхшээлтэй нүүр тулсан цаг үед бага зэргийн тусламж дэмжлэг авснаар амьжиргаагаа хадгалж үлдэх боломжтой малчин өрхүүдийн тогтвортой байдал, тэгш боломжийг хангах тал дээр улс төрийн хоосон орон зай үүсээд байгаа ажээ.

Малчдын тэгш эрхийг хангасан байдлаар орон нутгийн түвшний шийдвэр гаргалтыг “бүх нийтийн эрх ашиг”-т нийцүүлэх зорилготой өмнөх үеийн оролдлогууд нь зөвлөлтийн маягийн нэгдэл, хоршооллын хэлбэрүүд, үүнээс өмнө бол бурханы шашны сүм хийд, засаг ноёд, тайж язгууртны харьяалал, зохицуулалт зэрэг хэлбэр загвартай байсан. Эдгээр хэлбэр загвар бүр нь өөр өөрийн сул тал, ээдрээ, алдаа мадагтай ч сайн талуудыг нь сорчлон сонгож аваад, цөөн болон дундаж хэмжээний малтай малчдын цаг зуурын асуудлыг орон нутагтаа илүү үр дүнтэй шийдэж чадах улс төрийн уян хатан тогтолцоог бий болгоход ашиглаж болох юм.

- Монголын соёл, түүхийн мэдлэгийг XXI зуунд хөгжүүлэн тэлэх нь

Монголчуудын дийлэнх нь бичиг үсэгтэйн дээр мэдээллийн цахим болон бусад эх сурвалжуудыг ашиглах боломжтой юм. Гэтэл маш өндөр боловсролтой

хүмүүсийн дунд ч гэсэн зөвлөлтийн эрин үеэс өмнөх Монголын түүх, соёл, шашны баялаг түүхийн тухай мэдлэг тун бага, зөвхөн Чингис хаан, Монголын эзэнт гүрний талаарх наад захын ойлголтоор хязгаарлагдах төдий л байна.

Энэ асуудал нь мэдлэг боловсролтой иргэдтэй байх нийгмийн үнэт зүйлийн төлөвшүүлэх, эсвэл зөвлөлтийн үеийн үзэл суртлын өнөөг хүртэл мэдрэгдсээр байгаа ул мөрийг арилгахаас хамаагүй өргөн хүрээтэй асуудал юм. Монгол өнөөдөр нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын чухал асуудлуудыг хамарсан өргөн хүрээний асуудлуудтай нүүр тулаад байна. Улс төрийн удирдагчид болон Монголын олон нийт эдгээр сорилтыг шийдэх өөрийн орны онцлог бөгөөд нийгмийн хөгжлийн орчинд нийцсэн шинэлэг арга замыг эрэлхийлж буй энэ үед Монголын түүхийн өмнөх үеийн сургамж, өөрийн соёлын баялаг эх сурвалжийг илүү өргөнөөр ашиглах нь зүйтэй. Ингэснээр хөрөнгө баялгийн ялгаа гүнзгийрч байгаа энэ үед ялангуяа залуучуудын дунд үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах фашист үзлийг сонирхж улс төрийн чиг баримжаа болгох хандлагатай байгаа энэ үед Монгол үндэстнийг Халх Монголын цэвэр цусны удам угсаагаар хязгаарлах хэт энгийн төсөөллийг таягдан хаяхад туслах юм.

Зуу зуун жилийн туршид үр өгөөжөө өгсөн бүс нутаг, орон нутаг, үндэсний түвшинд улс төр, эдийн засаг, нийгмээ зохион байгуулах өвөрмөц загвар хэлбэрүүдийг Монголчууд хөгжүүлэн ашиглаж байсныг Монголын түүхийн баримтууд бэлхнээ гэрчилнэ. Орчин үеийн төрийн захиргааны олон чухал зарчмын зэрэгцээ өмнөх үеийнхээ Монголын бурханы шашин, бэлчээрийн мал аж ахуй, нүүдэлчин ахуйтай холбон үздэг үнэт зүйлсийг сэргээн, нийгмийн бүтцийн дээрх түвшнүүдийг бие биетэйгээ болон байгаль орчинтойгоо тэнцвэртэй байхаар зохион байгуулахад ашиглаж болох талтай.

Хэдийгээр өнгөрсөн үе улиран өнгөрсөн ч гэлээ үлдээсэн өв, сургамж нь соёлын чухал эх сурвалж болж өнөөг хүртэл хадгалагдсаар байгаа. Нэг талаас ард түмний дунд үндэсний бахархлыг өдөөн бэхжүүлэх, нөгөө талаас улс төрчид, нийгмийн манлайлагчдад XXI зууны сорилт бэрхшээлүүдийг Монгол арга барилаар чадварлаг шийдэх арга замыг гүнзгийрүүлэн судалж, бүтээлчээр эрэлхийлэхэд Монголын өнгөрсөн үеийн соёл, түүх, шашны тухай мэдлэгийг илүү өргөн хүрээтэй, илүү бүтээлчээр ашиглах боломж байна. Энэ утгаараа Монголчууд “улам Монголжих”-ын зэрэгцээ өөрийн орныг олон үндэстэн, олон шашинт улс мөн болохыг хүлээн зөвшөөрч гол давуу талаа болгох хүсэл, чадавхитай ард түмэн юм.